



Оксфордын
үншлэгтын
мод

БАГШИЙН НОМ

Шатлал 1
Үлгэрүүд



Родерик Хант
Алекс Бричта

Шатлал 1

Үлгэрүүд

Жилл Хаувел

Багшийн ном

Агуулга

Өмнөх үг	2
Үгсийн сангийн хүснэгт	4



Аавын бэлэгнүүд

Үнших үйл ажиллагаа	5
Ярих болон сонсох үйл ажиллагаа	7
Бичих үйл ажиллагаа	7



Ноход юунд дуртай вэ?

Үнших үйл ажиллагаа	8
Ярих болон сонсох үйл ажиллагаа	10
Бичих үйл ажиллагаа	10



Шилдэг нохой

Үнших үйл ажиллагаа	11
Ярих болон сонсох үйл ажиллагаа	12
Бичих үйл ажиллагаа	13



Намайг асраарай

Үнших үйл ажиллагаа	14
Ярих болон сонсох үйл ажиллагаа	15
Бичих үйл ажиллагаа	16



Түрүүлээрэй ээж ээ

Үнших үйл ажиллагаа	17
Ярих болон сонсох үйл ажиллагаа	19
Бичих үйл ажиллагаа	19

Өмнөх үг

Шатлал 1 сурх бичиг нь Биф, Чил, Киппер болон тэдний гэр булийн тухай таван нэмэлт өгүүлэгийг багтаасан юм. Үг сурх бичгийг бага насын хүүхдийг уншуулж сургах арга барил дээр үндэслэн бичсэн болно. Хүүхдүүд Шатлал 1 сурх бичгийг судалснаар энгийн шууд хэллэгүүдийг багтаасан төгс өгүүлбэрүүдээр бичсэн өгүүлэгүүдтэй танилцах юм.

Энэхүү товхимолд нийт арван хоёр өгүүлэгээс таван өгүүлэгийн заах аргачлалыг багтаасан болно. Өгүүлэгүүд дэх хэл нь давтамж болон загварын хувьд бага насын уншигчдад дөхөм болох байдлаар бичигдсэн.

Өгүүлэг бүрийн арын хуудсанд байнга олон удаа давтагдан хэрэглэгддэг үгүүдийн жагсаалтыг багтаасан билээ.

Номыг хэрхэн танилцуулах вэ?

Өгүүлэгүүдийг багшийн удирдлагын дор болон өөрөө бие даан унших эхлэхдээ гарчгийг уншаад номын нүүрэн дээрх зурагны тухай яриарай.

Хүүхдүүтэйгээ хамт номын зургийг харж ярилцсаны дараа ном уруугаа орж уншаарай. Хэрэв унших явцад шинэ болон танил бус мэдэхгүй үг (энэ номын 4-р хуудасны хүснэгтэнд жагсаасан үнгүүдээс) таарапдал хүүхдүүдээр өөрсдөөр нь олуулж уншуулаарай. Багш өгүүлэгийг хүүхдүүдэд унших өгөхдөө тэдэнд өөртөө итгэх итгэл олж авахад нь тусалж, тэдэнтэй холбоотой байгаарай.

Үг сурх бичиг нь хүүхдүүдэд сэргээн санах, санал дэвшүүлэхэд нь туслах замаар өгүүлэгүүдтэй танилцуулах юм. Мөн түүнчлэн уг номыг хэсэг, бүлгийн болон бие даасан үйл ажиллагаанд эх, өгүүлбэр, үгийн төвшинд хэрэглэж болох талаар хэд хэдэн санал оруулсан байгаа. Бас шат бүхэнд дээрх таван гарчигт зориулан звлүүлэн унших зориулалт бүхий тусгай картыг оруулсан. Энд дэвшүүлж буй санал зөвлөгөөнүүд нь сонсох, ярих, бичих үйл ажиллагаа болон хөтөлбөрийн уялдаа холбоог хангахад чиглэж байгаа юм.

Гэрийн карт- Ном бүхэнд гэртээ уншихад зориулагдсан бэлэн карт бий. Эдгээр нь эцэг эхчүүдийг хүүхдүүдтэйгээ ажиллахыг нөхөрсгөөр сануулсан санамж болж егдэг юм. Номын гарчиг бүхэнд хамарагдах картыг та гэртээ үлдээж болно.

Унших чадвараа хөгжүүлснээр

Шатлал 1-ийг уншсанаар:

- Эхийг ойлгосноор хүмүүжикж төлөвшинө.
- Номтой ажиллаж сурна.
- Усэг бол авианы тэмдэглэгээ болохыг ойлгосноор ухамсарт уншилт төлөвшинө.

Үгсийн сангийн хүснэгт

Аавын бэлэгнүүд	олон давтагдах үгс	аав, үүний, танд, энэ
	эхэд хамаарагдах үгс	хайрцаг, боодол, шоколадны цуглуулга, цэцгийн баглаа, усан үзэмний мөчир
Ноход юунд дуртай вэ?	олон давтагдах үгс	нохой, дуртай, тоглох, тэд
	эхэд хамаарагдах үгс	Флоппи, хөөцөлдөх, давхих, усанд орох
Шилдэг нохой	олон давтагдах үгс	том, нохой, бол, дуртай, харах, бид, энд, жижиг, таалагдах
	эхэд хамаарагдах үгс	бүгдээс, илүү, жижигхэн, шилдэг
Намайг асраарай	олон давтагдах үгс	бол, таалагдах, дээр, тэр, дээш, бид
	эхэд хамаарагдах үгс	Кейт, гулсуур, тор, пуужин
Түрүүлээрэй ээж ээ	олон давтагдах үгс	бол, яваарай, би, ээж, дээр, хэлэв
	эхэд хамаарагдах үгс	дахиад, Биф, Чип, явж байна, Кипер, явахгүй



Аавын бэлэгнүүд

Үншихын өмнө

- Хүүхдүүдээр гарчгийг уншуулж, хавтсан дээрх зургийг харуулаад тэднээс: Аавд юу тохиолдсон бэ? Тэр хаана байгаа вэ? Чи ер нь эмнэлэгт очиж байсан уу? Чи хэнтэй уулзах гэж явсан бэ? гэж асуу.
- Номыг гүйлгэн хараад автайт уулзахаар эмнэлэг дээр хэн эргэж ирснийг тодруул. Хүүхдүүд түүнд ямар бэлэг өгсөн бэ? гэж асуу.

Үнших үед

- Хүүхдүүдээр өгүүллэгийг уншуулахдаа сайшааж дэм үзүүл, шаардлагатай бол санамж өг.

Ажиллалт

Хүүхдүүдийг шалгахдаа:

- Цагаан толгойн үсэг болон авиа зүйн мэдлэгийг ашиглан танил бус үгүүд дээр ажилла.
- Зүүнээс баруун тийш зэнгөөр нь уншуул.
- Номын тухай илэрхийлийг зөв хэрэглэ.
- Эхийн доторх харилцан шүтэлцээг ашиглан агуулгыг ойлгох сэжүүр гарга.

Бүлгээр болон гацаарчлан үнших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Уншсан эхийн гол агуулгын талаар бусдадаа эрэмбэ дараалалтай тоочин ярь.

- Хүүхдүүдээс асуу: Аав хаана байна вэ? Түүнийг эмнэлэгт байгааг чи хэрхэн мэдсэн бэ? Аавын авсан анхны бэлэг юу вэ? Аавын авсан гурав дахь бэлэг юу вэ? Багц усан үзэм яасан бэ? Аавын авсан дөрөв дэх бэлэг юу байв? Өгүүллэгийн төгсгөлд шоколадууд яасан бэ?

Ажиглалт

Киперийг усан үзэм идэж байгаа тухай уншаад идсэнд дараа юу болох талаар хүүхдүүд урьдчилан төсөөлж байгаа үгүйг ажиглах.

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт Карт дээр цэцэг, шоколад, жигнэсэн буурцаг, сүү, усан үзэм гэж бич. Самбар дээр доорх өгүүлбэрийн хэсгийг бичээд хажууд нь уг бичсан картаа тогтоо.

Энэ бол нэг ут	цэцэг
Энэ бол нэг сав	шоколад
Энэ бол нэг түрүү	жигнэсэн буурцаг
Энэ бол нэг хайрцаг	сүү
Энэ бол нэг лонх	усан үзэм

- Өгүүлбэрүүдийг хүүхдүүдээр уншуулж утгыг ойлгож буй эсэхийг хэлүүл.
- Дараа нь үгүүдийг өөрчлөөд зөв өгүүлбэр зохиолго.

Ажиглалт

Хүүхдүүд ойлголтоо шалгаж өгүүлбэрийг дахин уншиж байна уу? Хүүхдүүд тухайн сэдэв болон авиа зүйн мэдлэгээ ашиглан өгүүлбэрийн хэсгийг үгүүдтэй зөв холбож чадаж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт Тухайн сэдэвтэй холбоотой үгүүдийн цуглуулга хийх. Танд дараах үгүүдтэй карт хэрэг болно. (толгой, хөл, гар, бие, аавыг дүрсэлсэн зураг)

- Хүүхдүүдээр хүний биеийн гол хэсгүүдийг хэлүүлээд дараа нь тэд нараар дээрх үгүүдийг хүний биеийн бүтцийн дагуу зөв байрлалаар тавиул.

Ажиглалт

Хүүхдүүд карт дээрх үгүүдийг уншихдаа үгүүдийг эхний үсгээр нь таньж байгаа эсэх. Тэд зурган дээр үгүүдийг зөв байрлуулсан эсэх.

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Гол агуулгад анхаарлаа хандуулах, хамааралтай хэсгүүдийг оролцуулах, сонсогчдын хэрэгцээ шаардлагыг тооцлоо. Тэд нарын ойлгосон эсэхийг мэдэх үүднээс асуулт асуух. Тэдний зан араншин, сэтгэл хөдлөлийн байдлыг шинжлэх зорилгоор яриа болон үйл хөдлөл ашиглах.

- Бүлэг дотор нь нэг хүүхдийг аавын дурд тоглуул. Бусад нь ааваас хөлөө хэрхэн гэмтээсэн гэх мэтээр асуултууд асууна. Тэр осолд орсон уу? Юу тохиолдсон бэ? Хэн эмч дуудсан бэ? Тэр эмнэлэгт яаж очсон бэ? гэх мэт.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Өдөр тутмын ангийн сургалтыг тоглоомын аргатай холбож хамтран ажиллуулах. Жишээ нь: Танд түргэн эдгэхийг ерөөсен хэдэн мэндчилгээ хэрэг болно.

- Мэндчилгээнүүдийг хүүхдүүдэд үзүүл. Эдгээр мэндчилгээг илгээсэн хүмүүсийн тухай, яагаад эдгээр хүмүүс мэндчилгээ илгээх болсон тухай ярилц.
- Дараа нь хүүхдүүдээр аавд мэндчилгээ бичүүл. Тэдэнд мэндчилгээн дээрээ аавыг баярлуулах хөгжилтэй зураг зурахыг санал болго.

Амьдрал, хичээлийн уялдаа холбоо

- ◀▶ Хувийн, нийгмийн болон сэтгэл хөдлөлийн хөгжил. Бусдад халамж анхаарал үзүүлэх.



Ноход юунд дуртай вэ?

Үншихын өмнө

- Хүүхдүүдээр гарчгийг уншуулж хавтсан дээрх зургийг харуулаад: Бифийн барьж буй номын гарчиг юу вэ? Үүнийг та нар ямар төрлийн ном гэж бодож байна? Энэ өгүүллэг үү, эсвэл мэдээллийн ном уу? гэж асуу.
- Номыг гүйлгэн уншаад Флоппигийн хийх дуртай болон хийх дургүй зүйлүүдийг ангил.

Үнших үед

- Хүүхдүүдээр өгүүллэгийг уншуулахдаа сайshaаж дэмж шаардлагатай бол санамж өг.

Ажиглалт

Хүүхдүүдийг шалгахдаа:

- Танил бус үгүүдтэй ажиллахдаа үгийн эхний үсгүүдийг ашигла.
- Зүүнээс баруун тийш тааваар нь уншуул.
- Номын тухай илэрхийллийг зөв хэрэглэ.
- Эхийн доторх харилцан шүтэлцээг ашиглан агуулгыг гаргах сэжүүр гарга.

Бүлгээр болон ганцаарчлан үнших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Өгүүллэгийн гол чухал хэсгийг үншиж мэдэх.

Асуулт: Та нар Бифийн барьж буй номон дахь өгүүллэгийг үншиж чадах уу? Энэ ном Флоппигийн тухай ном уу? Энэ ном хэний тухай вэ? Энэ ямар төрлийн ном бэ? Биф яагаад энэ номыг үншиж байгаа юм бол? Номонд гарч байгаа бүхнийг Флоппи хийх дуртай юу? Флоппи бүх ноходтой ижил зүйл хийх дуртайг өгүүлсэн хуудсыг надад харуулна уу?

Ажиглалт

Хүүхдүүд өгүүллэг болон мэдээллийн номын хоорондох ялгааг хэлж чадаж байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт Өгүүлбэрийн дурмийг таних, угийг тааварлах.

Танд дараах өгүүлбэрүүдэд тохирсон фото зургууд ба алхах, алхацаах гэсэн үг бүхий картууд хэрэг болно.

Тэд нар	дуртай.
Флоппи	дуртай.
Киппер	дуртай.
Биф Чип хоёр	дуртай.

- Хүүхдүүдээр хоосон зайл тохирох үгээр нөхүүлж бичүүл.

Ажиглалт

Хүүхдүүд үг сонгохдоо дурмийн мэдлэгээ зөв ашиглаж чадаж байна уу?

Тэд алдаагаа хянаж, өгүүлбэр бүрийг давтан уншиж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт Сүүх холбох мэдлэгээ ашиглан үг аялга болон үсэглэж дуудах хоёрыг хослуулан хэрэглэх.

Танд цагаан толгойн үсгүүд, нохой, муур гэсэн үгээр эхлэж төгссөн богино шүлэг хэрэг болно.

- Хүүхдүүдэд нохой гэсэн үг орсон шүлэг бодож олохыг сануул. Үгүүдийг үсэглэж хэлэхэд цагаан толгойн үсгээр дасгал хийлгэ.
- Мөн муур гэдэг үг орсон шүлэг санахыг санал болго.

Ажиглалт

Хүүхдүүд шүлгийг амжилттай бичиж чадав уу?

Тэд утгатай ба утгагүй үгүүдийн хоорондын ялгааг таньж чадаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Гол агуулгад анхаарлаа хандуулах, хамааралтай хэсгүүдийг оролцуулах, бусдын хариу үйлдлийг сонсон олж мэдсэн мэдлэгийн талаар санал бодлыг нь солилцуулах.

Танд Флоппи хүүхэлдэй, бусад тоглоомон нохой хэрэгтэй.

- Хүүхдүүдээр Флоппигийн зан араншингийн талаар яриул. Тэр ямар зүйл хийх дуртай болон хийх дургүй вэ?
- Хүүхдүүдийн авсан мэдлэг дээр тулгуурлан Флоппигийн тухай санал бодлыг яриул.
- Багийн хүүхэд бүрт Флоппигийн дүрд тоглохыг санал болго. Тэгээд хамгийн их хийх дуртай болон үзэн яддаг зүйлүүдийн нь тухай яриул.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Өгүүллэгийн талаарх суурь мэдлэг дээр нь үндэслэн бие даасан зохион бичлэг бичүүлэх. Жишээ нь: хувиргалт хийх, олуулах г.м

- Хүүхдүүдээр бүх нохдын хийх дуртай зүйлсийг аль болох олныг хэлүүл (газар ухах, тоглох, харایх, хуцах)
- Хүүхдүүдэд Флоппигийн хийх дуртай үйлдлүүдээс нэгийг хийж байгааг харуулсан зураг зуруулаад доор нь «Флоппи дуртай.» гэсэн өгүүлбэр бичүүл.

Амьдрал, хичээлийн уялдаа холбоо

◀▶ Ертэнцийн тухай ойлголт болон мэдлэг. Мен амьд зүйлсийн онцлогийн талаар мэдэх.



Шилдэг нохой

Үншихын өмнө

- Хүүхдүүдээр гарчгийгүншүүлж, хавтсан дээрх зургийг харуулаад: Нохойн үзэсгэлэн юу гэж ойлгох вэ? Нохойн үзэсгэлэн дээр юу болсон бэ? гэж асуу.
- Гарчгийн тухай яриад, «Шилдэг нохой» гэдэг үг ямар утгатай вэ? Хэнийг шилдэг нохой болно гэж бодож байна вэ? гэж асуу.

Үнших үед

- Хүүхдүүдээр өгүүллэгийг үншуул ахдаа сайшааж дэмж, шаардлагатай бол санамж өг.

Ажиглалт

Хүүхдүүдийг шалгахдаа:

- Танил бус үгүүдтэй ажиллахдаа үгийн эхний үсгүүдийг ашигла.
- Зүүнээс баруун тийш тааваар нь үншуул.
- Номын тухай илэрхийллийг зөв хэрэглэ.
- Эхийн доторх харилцан шүтэлцээг ашиглан агуулгыг ойлгох сэжүүр гарга.

Бүлгээр болон ганцаарчлан үнших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Янз бүрийн хүрээний (тэмдэг, шошго г.м) хэвлэмэл болон гараар бичсэн үгүүдийг таньж мэдэх.

Асуулт:

- Та нар номон доторх тэмдгийг зааж үзүүлнэ үү? Энэ юу гэсэн үг вэ? Энэ хуудасны хaa нэгтээгээс «нохой» гэдэг үг олж чадах уу? Надад том болон жижиг «н» үсгийг харуулна уу?

Ажиглалт

Хүүхдүүд тэмдгийг амархан олж чадаж байна уу?
Тэд «нохой» гэдэг үгийг дармал том болон жижиг үсгээр амархан бичиж чадаж байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах**Зорилт**

Өгүүлбэр дэх дүрмийг мэддэг болох, өгүүллэгийг дахин уншихдаа үгүүдийг тааварладаг болох.

Номын 4, 5-р хуудсан дээрх бүх үгийг нэг бүрчлэн бичсэн карт бэлдэх хэрэгтэй. (бид, дуртай, энэ, нохой, энэ бол, том нохой)

- Үгүүдийн байрыг сольж бичээд хоёр өгүүлбэр зохиохыг санал болго.

Ажиглалт

Хүүхдүүд дүрмийн мэдлэгээ ашиглан өгүүлбэрт орох үгүүдийг сонгож чадаж байна уу?

Өгүүлбэрийн эхэнд орох том үсгээр эхэлсэн үг, адагт орох тэгсгэлийн үгийг зөв сонгож чадаж байна уу?

Үгийн төвшинд ажиллах**Зорилт**

Тухайн сэдэвтэй холбоо бүхий үгүүдийн цуглуулга хийх.
Танд мэн Флоппигийн зураг хэрэгтэй.

- Хүүхдүүдэд мэдээллийн номноос нохойны биеийн эрхтнүүд өөрөөр нэрлэздгийг мэдүүлэх.
- Зураг дээр нохойны эрхтнүүдийн нэрийг наах.

Ажиглалт

Хүүхдүүд нохойны эрхтнүүдийн нэрийг ялгаж, үгийг зөв сонгож чадаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа**Зорилт**

Эзлэхээр ярих, янз бүрийн байдлыг харгалзан дүгнэх, учир шалтгааныг гаргах.

Танд 4 тоглоомон нохой, эсвэл зураг, мэн нохой бүхэнд зориулсан онооны хуудас хэрэгтэй.

- Хүүхдүүдийг нохойны шоуг шүүх гэж буй дүрд тоглохыг санал болго.
- Дөрвөн нохойг тэдэнд харуулж, нохой бүрт 10 онсоо өгөн, оноог онооны хуудас дээр бичих.
- Тэгээд авсан онооноогоор нь тэднийг 1, 2, 3 дугаар байр эзлүүлж нэг нохойд «Бүхнээс шилдэг» цол өгнө.
- Баг бүрээс нэг хүүхдэд ямар нохой шилдэг болсныг зарлахыг даалга.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Өдөр тутмын ангийн сургалтыг тоглоомын аргатай холбож хамтран ажиллуулах.

Танд картууд, нимгэн цаас, цавуу, харандаа хэрэг болно.

- Өгүүллэг дэх нэrsийн жагсаалтыг хүүхдүүдэд харуулж карт болон нимгэн цаасан дээрээ 4 жагсаалт хийхийг санал болго.
- Жагсаалт дээрээ 1, 2, 3 дугаар байр, «Хамгийн шилдэг» гэж бичнэ.
- Шоунд орсон нохой бүрийг жагсаалтанд хамруулна.
- Тэгээд «Хамгийн шилдэг» шагнал авсан нохойг хүүхдүүдээр зуруулна.

Амьдрал, хичээлийн уялдаа холбоо

◀► Математик хөгжил: Жагсаалтанд байгаа нэrsийн дугаарыг хэлэх.



Намайг асраарай

Уншихын өмнө

- Хүүхдүүдээр гарчигийг уншуулж хавтсан дээрх зургийг харуулаад: Хүүхдүүд хаана байна вэ? Та нар зураг дээр харагдаж буй зан авирыг дүрсэлж чадах уу? Хэнд асрамж хэрэгтэй юм шиг байна? Яагаад? гэж асуу.
- Өгүүллэгийг гүйлгэн уншаад Кейтийн хийдэг зүйлүүдийг тооч. Түүнийг вөртөө сэтгэл хангалиун явдаг гэж бодож байна уу? Биф Чип Ульма нар ямархуу байна вэ? Кейтийг унтахад тэд ямархуу байв? Яагаад? гэж асуу.

Унших үед

- Хүүхдүүдээр өгүүллэгийг уншуулахдаа сайшааж дэмж, шаардлагатай бол санамж өг.

Ажиглалт

Хүүхдүүдийг шалгахдаа:

- Танил бус үгүүдтэй ажиллахдаа үгийн эхний үсгүүдийг ашигла.
- Зүүнээс баруун тийш тааваар нь уншуул.
- Номын тухай илэрхийллийг зөв хэрэглэ.
- Эхийн доторх харилцан шүтэлцээг ашиглан агууллыг ойлгох сэжүүр гарга.

Бүлгээр болон ганцаарчлан унших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Судалсан эхийн талаар бусдад эргүүлэн ярих, гол утгыг дэс дараалалтай хүүрнэж ярих

- Асуулт: Хүүхдүүд хаана байсан бэ? Кейт анх удаа, хоёр дахь, гурав дахь удаагаа хаашаа явсан бэ? Биф, Чип, Ульма нар Кейтийг хэрхэн асрамжилсан бэ? Тэд юу хийсэн бэ? Эцэст нь Кейтэд юу тохиолдсон бэ? Түүнийг яагаад унтсан гэж бодож байна вэ? Өгүүллэгийн төгсгөлд хүүхдүүд ямар байдалтай байв?

Ажиглалт

Өгүүллэгийн төгсгөлд Кейт яагаад унтсаныг хүүхдүүд ойлгож байна уу?

Өгүүллэгийн төвшинд ажиллах**Зорилт**

Үгүүд нь зүүнээс баруун тийш дараалалтай байх ба утга төгөлдөр байх хэрэгтэй.

Танд дараах үгүүдтэй карт хэрэг болно. (тэр, гар, дээр, торой)

- Үгүүдийг хольж замбараагүй байрлалд оруулаад хүүхдүүдээр зөв өгүүлбэр зохиолгох.

Ажиглалт

Хүүхдүүд үсгийг зөв сонгож чадаж байна уу?

Өгүүлбэрийн утгыг шалгаж дахин уншиж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Олон удаа давтагдах үгүүдийг олж унших

- Хүүхдүүдээс: Энэ эхийг уншихдаа «авирав» гэдэг үтгэй хэдэн удаа тааралдсан бэ? гэж асуу.
- Тэгээд хүүхдүүдэд 8 дугаар хуудсыг эргүүлэхийг санал болгоод «авирав» гэдэг уг орсон өөр өгүүлбэрийг уншуул.

Ажиглалт

Хүүхдүүд «авиrah» гэдэг үгийг янз бүрийн хэлбэрээр уншиж чадаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа**Зорилт**

Анхаарлаа төвлөрүүлэх, эзлж эзлжээр ярих, болоод өнгөрсөн зүйлтэй тэдний сонирхлыг холбох.

Та самбар дээр дараах өгүүлбэрийг бичих хэрэгтэй.

Би тоглоомын талбайд очоод дээр гарав.

- Хүүхдүүдийг жижиг буulgээр зохион байгуулаад тоглоомын талбай уруу очсон байдлаар төсөөл. Ямар төрлийн тоглоомын хэрэгсэл чи авч явах вэ? гэж асуу.
- Хүүхдүүдийг баг дотор нь гар гараас нь хөтлөлцүүл.

- Эхний хүүхэд нэг тоглоомын нэр хэлэхэд дараачийн хүүхэд түүний хэлсэн дээр нэмж, өөр нэг тоглоомын нэр хэлэх байдлаар үргэлжилнэ.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Яңз бүрийн тоглоомын нөхцөл байдалд бичих дадлага хийх.
Бичихээр төлөвлөсөн зүйлийнхээ тухай ярилцах ба бичих.

- Хүүхдуудээс хамгийн аятайхан тоглоомын газрын тухай асуу. Гадаа байсан уу, эсвэл дотор байсан уу? Тэнд ямар ямар тоглоомнууд байсан бэ? Бага насныханд зориулсан тусгай хэсэг байсан уу? Энэ хэсэгт ямар төрлийн хэрэгслүүд байсан бэ? Гэх мэт.
- Хүүхдуудээр хамгийн дуртай тоглоомын хэрэгслийг нь зуруулж өгүүлбэр бичүүл.



Түрүүлээрэй ээж ээ

Үншихын өмнө

- Хүүхдүүдээр гарчгийг уншуулж хавтсан дээрх зургийг харуулаад ээж юу хийх гэж байгааг асуу.
- Номыг гүйлгэн уншаад ээжийг хөгжилтэй уралдаанд гүйлгэхэд хүргэсэн зүйлүүдийг олж тогтоо. Энэ байдал хөгжилтэй харагдаж байна уу? Ээж сүүлдээ яагаад гүйхээ больсон бэ? гэж асуу.
- 1-р хуудсанд байгаа хэллэг дээр анхаарлаа хандуулаад: Чип ямар үг хэлсэн бэ? Түүний хэлснийг чи юу гэж бодож байна? гэж асуу.

Үнших үед

- Хүүхдүүдээр өгүүллэгийг чанга уншуулахдаа сайшааж магт, дэмж, шаардлагатай бол санамж өг.

Ажиглалт

Хүүхдүүдийг шалгахдаа:

- Олон давтгадах үгүүдийг харуулж уншуул.
- Уншуулахдаа зүүнээс баруун тийш тааваар нь уншуулна.
- Номын нэр томьёог зөв хэрэглэж буйг анхаар.

Бүлгээр болон ганцаарчлан үнших үйл ажиллагаа

Эхийн төвшинд ажиллах

Зорилт Эхийн чухал хэсгүүдийг олж үнших.

- Асуулт: Номноос хэдэн тэмдэглэгээ олж чадах вэ? Үүнийг надад үзүүлж чадах уу? «Түрүүлэх» гэдэг үг ямар утгатай вэ? Өөр ямар уралдаанд тойрот байдаг вэ? Хөгжилтэй гүйлтийг хэн зохион байгуулж байна вэ? Та нар надад нэг цэргийг зааж өгнө үү? Армийн сургалт ээж юу вэ? Цэргүүд яагаад сургуулилт хийх хэрэгтэй байдаг вэ? Энэ өгүүллэгт хэн хөгжилтэй байна вэ? Ээж хөгжилтэй байна уу? Бусад ээжүүд хөгжилтэй байна уу?

Аав болон хүүхдүүд хөгжилтэй байна уу? Үүнийг та нар хөгжилтэй гүйлт гэж бодож байна уу?

Ажиглалт

Хүүхдүүд зурагт үзүүлсэн эх болон түүхэн өгүүллэгийн хоорондын ялаага ойлгох байна уу?

Өгүүлбэрийн төвшинд ажиллах

Зорилт Эхтэй танилцаад дахин уншихдаа хүүхдүүд өгүүлбэр дэх дурмийг ойлгох, үгийг урьдчилан төсөөлөх

Танд бүх уг болон цэг таслалыг бичсэн карт хэрэгтэй. «Түрүүлээрэй ээж ээ» гэж Чип хэлэв гэсэн өгүүлбэрийг жишээ болгон ав.

- Үгүүдийг замбараагүй байрлалд оруулаад, хүүхдүүдээр зөв дараалалтай өгүүлбэр бүтээлгээ.
- Хүүхдүүдэд өгүүлбэрт байгаа «хэлэв» гэдэг үгийг орлох веर сонирхолтой үгийг олохыг санал болго. Тэдгээр үгийг самбар дээр бич.

Ажиглалт

Хүүхдүүд үгүүдийг зөв дараалалд оруулахдаа өгүүлбэрийн тэмдэг зуултуудийг хэрэглэж байна уу?
Тэд өгүүлбэр зөв эсэхийт шалгаж дахин уншиж байна уу?

Үгийн төвшинд ажиллах

Зорилт Үгийн дуудлагыг үсэглэж унших загвартай хослуулах.
Та самбарт «явлж байна» гэдэг үгийг бичих хэрэгтэй.

- «байна» төгсгөлийг дараад хүүхдүүдээс ямар уг болохыг асуу.
- «явлж» гэдэг үгийг дарж байгаад хүүхдүүдээр төгсгөлийг нь уншуул.
- Хүүхдүүдээс энэ номноос «явлж байна» гэдэг үгийг хэдэн удаа олж харсныг асуу.
- Хүүхдүүдээр номыг гүйлгэн харуулаад зураг дээрх хүмүүс юу хийж буйг дүрслэн хэлүүл. Хүүхдүүдээр «байна» төгсгөлтэй веर үгүүдийг хэлүүл.
- Үгүүдийг самбар дээр бичиж, хүүхдүүдтэй хамт унш.

Ажиглалт

Хүүхдүүд «байна» туслах үйл үтийг ашиглан зураг дээрх үйлдлийг дүрсэлж чадаж байна уу?

Ярих болон сонсох үйл ажиллагаа

Зорилт Гол агуулга дээр анхаарлаа хандуулах, холбогдох хасгүүдийг нэг бүрчлэн оруулах, ярианд ээлж ээлжээр оролцуулах, үйл явдлуудыг дүрслэх.

- Үгүүдийг хайрцагнаас гаргаж хүүхдүүдээс ээлжлэн асуу.
- Хүүхэд бүрт үгийг уншуулж хажуу дахь хүүхдийг удирдуул. Удирдуулж буй хүүхэд үйл хөдлөлөөр үйлдлийг гүйцэтгэнэ. Юу хийж байгаагаа өөрөө хэлнэ.
- Номонд байгаа зээкийн зураг бур дээр юу хийх гэж байгааг нь дүрслүүл. Тэгээд нэг хүүхдийг тэмцээн тайлбарлагчийн дурд тоглуулж юу болсныг дүрслүүл.

Амьдрал, хичээлийн уялдаа холбоо

◀ ▶ Биеийн хөгжил: Удирдлага болон хяналтан доор хөдөлгөөн хийх.

Бичих үйл ажиллагаа

Зорилт Тоглоомын янз бүрийн нэхцэлд бичих дадлага хийх. Танд цаас, хараандаа, хайч хэрэг болно.

- Хүүхдүүдээр хоёр ярианы бөмбөлөг зуруул. Нэгэнд нь «Түрүүлээрэй ээж ээс нөгөөд нь «Би явж байна» гэж бичүүл.
- Хүүхдүүдээр хайчлуулаад зураг бүхэн дээр дүрүүдийн яриаг байрлуул.



Оксфордын уншлагын мод

Шатлал 1
Анхны
өгүүлбэрүүд

Оксфордын уншлагын мод цувралын шатлал 1 нь олон давтагдах угсийг хэрэглэж бүтэн өгүүлбэрээр хүүрнэн ярих хэлбэрээр бичигдсэн. Хүүхдүүдийг өөртөө итгэлтэй чөлөөтэй ярж сурахад үлгэрүүд нь чухал нелее үзүүлдэг.

Гарчиг бүр дэх багшийн тэмдэглэлүүд нь:

- Уншихын өмнөх санамж зөвлөгөө өгөх
- Бүлгээр болон бие дааж уншихдаа эх, өгүүлбэр үгийн төвшин дэх үйл ажиллагаагаар хангах
- Сонсох, ярих үйл ажиллагааны санаануудыг гаргах
- Бичих үйл ажиллагааны санааг гаргах
- Амьдрал-хичээлийн уялдаа холбоо

Эдгээр нь:

- Харилцан хамаарал бүхий угсийн сангийн хүснэгт
- Оксфордын уншлагын мод цувралтай холбогдох бусад материалууд

Гэрийн картууд нь мөн хэрэг болно. Эдгээр нь гэртээ хүүхдүүдтэйгээ энэхүү номыг уншдаг эцэг эхчүүдэд нөхөрсөг санамж зөвлөгөө өгч, тоглоомоор хангадаг юм.

БАГШИЙН НОМ



Хэвлэн нийтлэлийг
Интерпресс ХХК



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй «Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.